

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ТӨВИЙН 2020 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН
САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

Аудитын код: ХОА-2021/5/СТА-ТШЗСН

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Ховд хот 2021 он</p>	<p>Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 70433061 Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас:70432545 Цахим хаяг: Tsetsegsuren.A@audit.gov.mn Аудитор: Б.Должинжав Утас: 70432545 цахим хаяг: Doljinjav.b@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

<i>АДБОУС</i>	<i>Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт</i>
<i>АОУС</i>	<i>Аудитын Олон Улсын Стандарт</i>
<i>УСНББОУС</i>	<i>Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт</i>
<i>ТТЗ</i>	<i>Төсвийн төвлөрүүлэн захирагч</i>
<i>ТШЗ</i>	<i>Төсвийн шууд захирагч</i>
<i>ХХОАТ</i>	<i>Хувь хүний орлогын албан татвар</i>

Агуулга

1.Төрийн аудитын байгууллагын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	11
3. Аудитын тайлан.....	11
3.1. Ерөнхий зүйл.....	11
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	12
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт	12
3.4. Материаллаг байдал	13
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	13
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	15
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	16
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
3.9. Аудитын илрүүлэлт.....	16
Залруулсан алдаа.....	17
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	17
Аудитын зөвлөмж.....	17
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	17
4. Менежментийн захидал	17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	18

1. ТӨРИЙН АУДИТЫН САНАЛ, ДҮГНЭЛТ



ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

2021.02.25 № 2/85
танай _____ -ны № _____ -т

ХОВД АЙМГИЙН ЗООНОЗЫН ӨВЧИН
СУДЛАЛЫН ТӨВИЙН ДАРГА Б.БАЯРЖАРГАЛ
ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Зоонозын өвчин судлалын төвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Зоонозын өвчин судлалын төвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл нь байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, үйл ажиллагааны тайлан, хууль тогтоомжид нийцүүлэн төрийн үйлчилгээг ард иргэдэд чанартай ил тод, тэгш хүргэх зэрэг санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

00100025/

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.БОЛДБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН
2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН /төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	21,277,956.60	37,313,122.60
33	АВЛАГА	5,223,061.60	930,607.60
33300	Татаас, санхүүжилтийн авлага	2,693,992.00	00.00
335	Бусад авлага	2,529,069.60	930,607.60
3351	Байгууллагаас авах авлага	2,529,069.60	930,607.60
34	УРЬДЧИЛГАА	211,813.00	211,813.00
3471	Урьдчилгаа тооцоо	211,813.00	211,813.00
34713	Цалингийн урьдчилгаа	211,813.00	211,813.00
35	БАРАА МАТЕРИАЛ	15,843,082.00	36,170,702.00
351	Түүхий эд материал	4,729,126.00	29,630,626.00
35130	Эм боох материал	4,729,126.00	29,630,626.00
354	Хангамжийн материал	11,113,956.00	6,540,076.00
35410	Бичиг хэргийн материал	236,180.00	00.00
35430	Сэлбэг хэрэгсэл	764,000.00	00.00
35470	Бусад хангамжийн материал	10,113,776.00	6,540,076.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	324,380,467.51	352,589,570.65
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	324,380,467.51	352,589,570.65
392	Биет хөрөнгө	137,440,467.51	165,399,570.65
39201	Барилга, байгууламж, орон сууц	54,780,140.00	54,780,140.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-9,846,423.35	-22,372,590.11
39203	Авто-тээврийн хэрэгсэл	50,964,200.00	122,702,200.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-43,730,866.44	-56,484,477.46
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	175,315,283.52	176,215,183.52
39206	Хуримтлагдсан элэгдэл	-93,980,430.27	112,672,528.43
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	10,785,534.00	10,785,534.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-6,846,969.95	-7,553,890.87
393	Биет бус хөрөнгө	186,940,000.00	187,190,000.00
39301	Програм хангамж	545,000.00	795,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-545,000.00	-545,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	186,940,000.00	186,940,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	345,658,424.11	389,902,693.25
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	2,832,835.00	00.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,832,835.00	00.00
413	Өглөг	2,832,835.00	00.00
4136	Бусад өглөг	2,832,835.00	00.00
41361	Байгууллагад төлөх өглөг	2,734,845.00	00.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	97,990.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	342,825,589.11	389,902,693.25
51	Засгийн газрын хувь оролцоо	342,825,589.11	389,902,693.25
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	275,955,180.00	275,955,180.00

51101	Өмч: - төрийн	275,955,180.00	275,955,180.00
512	Хуримтлагдсан үр дүн	-76,945,941.89	-29,868,837.75
51210	Өмнөх үеийн үр дүн	-76,945,941.89	-76,945,941.89
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	47,077,104.14
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	143,816,351.00	143,816,351.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	345,658,424.11	389,902,693.25

2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	390,579,671.00	577,131,489.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	21,642,871.00	111,784,927.50
120	Нийтлэг татварын бус орлого	18,878,871.00	111,784,927.50
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	18,878,871.00	111,784,927.50
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	18,878,871.00	111,784,927.50
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	364,806,800.00	465,346,562.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	364,806,800.00	431,429,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	364,806,800.00	431,429,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6,894,000.00	33,916,662.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,894,000.00	24,117,460.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	2,693,992.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	7,105,210.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	383,609,268.56	530,054,385.36
21	УРСГАЛ ЗАРДАЛ	383,609,268.56	530,054,385.36
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	380,475,276.56	529,614,385.36
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	254,944,977.00	310,582,820.00
210101	Үндсэн цалин	179,682,652.00	188,337,826.00
210102	Нэмэгдэл	40,852,930.00	78,025,094.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	14,480,352.00	15,981,000.00
210104	Урамшуулал	19,929,043.00	28,238,900.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,322,438.00	44,745,200.00
210201	Тэтгэврийн даатгал	34,322,438.00	29,338,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	3,037,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	5,468,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	824,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	6,075,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	24,637,775.00	25,436,834.00
210301	Гэрэл, цахилгаан	1,238,021.00	1,891,254.00
210302	Түлш, халаалт	21,081,754.00	21,227,580.00
210303	Цэвэр, бохир ус	2,318,000.00	2,318,000.00

2104	Хангамж, бараа материалын зардал	20,106,328.00	33,794,640.00
210401	Бичиг хэрэг	1,665,600.00	11,331,180.00
210402	Тээвэр, шатахуун	13,713,000.00	18,219,760.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,562,700.00	731,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	60,000.00	422,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,105,028.00	3,089,700.00
2105	Нормативт зардал	9,639,900.00	54,365,337.50
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	8,704,500.00	42,737,917.50
210502	Хоол, хүнс	00.00	6,193,220.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	935,400.00	5,434,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,591,000.00	8,674,057.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,485,000.00	2,114,820.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	878,395.00
210604	Урсгал засвар	3,106,000.00	5,680,842.00
2107	Томилолт, зочны зардал	4,580,000.00	5,301,500.00
210702	Дотоод албан томилолт	4,580,000.00	5,301,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,192,300.00	2,035,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	350,000.00	480,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	207,900.00	207,900.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	237,200.00	237,200.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	50,500.00	34,900.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,052,700.00	1,075,200.00
210807	Газрын төлбөр	96,000.00	00.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	198,000.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	25,460,558.56	44,678,796.86
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	25,460,558.56	44,678,796.86
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,133,992.00	440,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	440,000.00	440,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	440,000.00	440,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,693,992.00	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,693,992.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	6,970,402.44	47,077,104.14
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	480,000.00	00.00
225002	Найдваргүй авлагын алдагдал	480,000.00	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-480,000.00	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	6,490,402.44	47,077,104.14

2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	371,700,800.00	465,346,562.00

13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	368,936,800.00	465,346,562.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	364,806,800.00	431,429,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	364,806,800.00	431,429,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6,894,000.00	33,916,662.00
131103	ЗГНХ,ЗДНХерөнгө,түүнтэй адилтгах ангилдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,894,000.00	24,117,460.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	2,693,992.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	7,105,210.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	371,700,800.00	465,346,562.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	371,700,800.00	465,346,562.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	368,566,808.00	464,906,562.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	255,826,200.00	309,880,100.00
210101	Үндсэн цалин	178,207,600.00	188,259,800.00
210102	Нэмэгдэл	44,551,900.00	77,400,400.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	15,246,000.00	15,981,000.00
210104	Урамшуулал	17,820,700.00	28,238,900.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,536,600.00	44,048,300.00
210201	Тэтгэврийн даатгал	34,536,600.00	28,859,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	3,037,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	5,468,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	607,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	6,075,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	24,678,100.00	25,810,200.00
210301	Гэрэл, цахилгаан	1,010,100.00	2,232,300.00
210302	Түлш, халаалт	21,350,000.00	21,259,900.00
210303	Цэвэр, бохир ус	2,318,000.00	2,318,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	19,847,900.00	29,426,610.00
210401	Бичиг хэрэг	1,635,000.00	5,435,000.00
210402	Тээвэр, шатахуун	13,713,000.00	17,514,760.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,409,900.00	685,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,800,000.00	1,800,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,290,000.00	3,991,650.00
2105	Нормативт зардал	16,453,000.00	36,738,660.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	10,544,000.00	26,169,000.00
210502	Хоол, хүнс	00.00	6,070,660.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,909,000.00	4,499,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,436,208.00	11,234,892.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,936,008.00	1,500,000.00
210602	Тавилга	5,000,000.00	499,900.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	480,000.00	2,320,500.00

210604	Урсгал засвар	3,020,200.00	6,914,492.00
2107	Томилолт, зочны зардал	4,580,000.00	5,301,500.00
210702	Дотоод албан томилолт	4,580,000.00	5,301,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,208,800.00	2,466,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	350,000.00	480,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	207,900.00	207,900.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	237,200.00	237,200.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	50,500.00	120,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,069,200.00	1,075,200.00
210807	Газрын төлбөр	96,000.00	96,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	198,000.00	250,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,133,992.00	440,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	440,000.00	440,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	440,000.00	440,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,693,992.00	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,693,992.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	00.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН /төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2019 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	275,955,180.00	143,816,351.00	-83,422,144.33	336,349,386.67
Тайлант үеийн үр дүн			6,476,202.44	6,476,202.44
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	275,955,180.00	143,816,351.00	-76,945,941.89	342,825,589.11

2020 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	275,955,180.00	143,816,351.00	-76,945,941.89	342,825,589.11
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	275,955,180.00	143,816,351.00	-76,945,941.89	342,825,589.11
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	47,077,104.14	47,077,104.14
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	275,955,180.00	143,816,351.00	-29,868,837.75	389,902,693.25

2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН /төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	431,429,900.00	431,429,900.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	431,429,900.00	431,429,900.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	430,989,900.00	430,989,900.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	305,780,100.00	305,780,100.00
210101	Үндсэн цалин	188,259,800.00	188,259,800.00
210102	Нэмэгдэл	73,300,400.00	73,300,400.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	15,981,000.00	15,981,000.00
210104	Урамшуулал	28,238,900.00	28,238,900.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	44,048,300.00	44,048,300.00
210201	Тэтгэврийн даатгал	28,859,300.00	28,859,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,037,800.00	3,037,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,468,000.00	5,468,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	607,600.00	607,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,075,600.00	6,075,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	25,810,200.00	25,810,200.00
210301	Гэрэл, цахилгаан	2,232,300.00	2,232,300.00
210302	Түлш, халаалт	21,259,900.00	21,259,900.00
210303	Цэвэр, бохир ус	2,318,000.00	2,318,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	23,064,000.00	23,064,000.00
210401	Бичиг хэрэг	2,435,000.00	2,435,000.00
210402	Тээвэр, шатахуун	15,793,800.00	15,793,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	685,200.00	685,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,800,000.00	1,800,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,350,000.00	2,350,000.00
2105	Нормативт зардал	16,599,000.00	16,599,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	12,100,000.00	12,100,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,499,000.00	4,499,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,920,500.00	7,920,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,500,000.00	1,500,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,200,000.00	2,200,000.00
210604	Урсгал засвар	4,220,500.00	4,220,500.00
2107	Томилолт, зочны зардал	5,301,500.00	5,301,500.00
210702	Дотоод албан томилолт	5,301,500.00	5,301,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,466,300.00	2,466,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	480,000.00	480,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	207,900.00	207,900.00

210804	Тээврийн хэрэгслийн татвар	237,200.00	237,200.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	120,000.00	120,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,075,200.00	1,075,200.00
210807	Газрын төлбөр	96,000.00	96,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	250,000.00	250,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	440000.00	440000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	440,000.00	440,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	440,000.00	440,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	431,429,900.00	431,429,900.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	431,429,900.00	431,429,900.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	431,429,900.00	431,429,900.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	23	23
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	22	22
620003	Үйлчлэх ажилтан		

2.6 АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	33,916,662.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	33,916,662.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	33,916,662.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,100,000.00
210102	Нэмэгдэл	4,100,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,483,110.00
210401	Бичиг хэрэг	3,000,000.00
210402	Тээвэр, шатахуун	1,720,960.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,762,150.00
2105	Нормативт зардал	20,139,660.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	14,069,000.00
210502	Хоол, хүнс	6,070,660.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,193,892.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	499,900.00
210604	Урсгал засвар	2,693,992.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	33916662.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	33,916,662.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	24,117,460.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,693,992.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	7,105,210.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

3.АУДИТЫН ТАЙЛАН

3.1. Ерөнхий зүйл

Зоонозын өвчин судлалын төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг байгууллагын дарга Б.Баяржаргал танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд бараа материалын зарцуулалтад бүртгэлээр хэрэгжүүлэх хяналт, нягтлан бодох бүртгэл, тайлагналын талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 18-наас 2021 оны 02 дугаар сарын 22-ны хооронд Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Должинжав хариуцаж хэрэгжүүлэв.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Зоонозын өвчин судлалын төв нь “Байгалийн голомтот зооноз өвчнийг тандах, хянах, эрт сэрэмжлүүлэх, хариу арга хэмжээг судалгаа, нотолгоонд тулгуурлан мэргэжлийн өндөр түвшинд зохион байгуулж, халдвар, хүн амын эрсдэлийг багасган, өвчлөл эндэгдлийг бууруулна” гэсэн эрхэм зорилгоо тодорхойлон ажилласан байна.

Зоонозын өвчин судлалын төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хүн амын дунд нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг оновчтой зохион байгуулах,
- Зооноз өвчний тархалт, тандалтын судалгаа хийх,
- Хүн амыг уг халдварт өвчинд өртөх эрсдэлээс сэргийлэх,
- Зоонозын өвчин, хүний өвчлөл гарсан тохиолдолд богино хугацаанд цомхотгон дарах

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт
- Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор “Төрийн албан хаагчийн цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”
- Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 183 тоот “бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай”
- Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 10 тоот “Төрийн болон орон нутгийн
- Засгийн газрын 2020 оны 151 дүгээр тогтоол

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Төсвийн байгууллага нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Цар тахлын улмаас Зоонозын өвчин судлалын төвийн санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой дотоод болон бусад хяналт, шалгалт 2020 онд хийгдээгүй байна.

Байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 383623.5 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 3836.2 мянган төгрөгөөр тооцсон.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 530054.3 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 5300.5 мянган төгрөгөөр тооцсон нь үр дүнгийн тайланд залруулга хийгдсэнээс хамаарсан болно.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Зоонозын өвчин судлалын төвийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 44244.3 мянган төгрөгөөр буюу 12.8 хувиар өсчээ.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
1	Эргэлтийн хөрөнгийн дүн	21,278.0	37,313.1	16,035.2
33	Авлага	5,223.1	930.6	-4,292.5
34	Урьдчилгаа	211.8	211.8	00.0
35	Бараа материал	15,843.1	36,170.7	20,327.6
2	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	324,380.5	352,589.6	28,209.1
39	Үндсэн хөрөнгө	324,380.5	352,589.6	28,209.1
392	Биет хөрөнгө	137,440.5	165,399.6	27,959.1
393	Биет бус хөрөнгө	186,940.0	187,190.0	250.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	345,658.4	389,902.7	44,244.3
4	Нийт өр төлбөр	2,832.8	00.0	-2,832.8
5	Цэвэр хөрөнгө өмчийн дүн	342,825.6	389,902.7	47,077.1
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	345,658.4	389,902.7	44,244.3

Авлага дансны оны эхний үлдэгдэл дэх 5223.1 мянган төгрөг нь нэмэлт санхүүжилтийн татан төвлөрүүлэлтийн 2694.0 мянга, нийгмийн даатгалын шимтгэлийн илүү төлөлт 1310.0 мянга, цалин хөлсний ХХОАТ-ын илүү төлөлт 1219.0 мянган төгрөгийн авлагуудаас бүрдсэн ба тайлант оны эцэс дэх 930.6 мянган төгрөгийн авлага нь гэрэл цахилгааны 349.6 мянга, цалин хөлсний ХХОАТ-ын илүү төлөлт 581.0 мянган төгрөгийн авлагаас тус тус бүрдсэн байна.

Бараа материалын данс оны эхэнд 15843.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба оны эцэст 36170.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй буюу өмнөх оны үлдэгдлээс 20327.6 мянган төгрөгөөр нэмэгджээ. Бараа материалын үлдэгдэл өмнөх оны мөн үеэс материаллаг хэмжээгээр нэмэгдсэн шалтгаан нь аймгийн онцгой комиссын хурлын шийдвэрээр Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлын горимд шилжүүлсэнтэй холбоотой 30000.0 мянган төгрөгийн бараа материал, хамгаалалтын хэрэгслийг аймгийн онцгой байдлын газраас хүлээн авч нөөц бүрдүүлснээс хамаарч өссөн байна.

Зоонозын өвчин судлалын төв нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 3487.9 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, Эрүүл мэндийн яамнаас 69400.0 мянган төгрөгийн өртөг

бүхий 2 тээврийн хэрэгсэл шилжүүлэн авч нийт 72887.9 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгджээ . Хүснэгтээр харуулбал:

Үзүүлэлт	Үндсэн хөрөнгийн оны эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	Худалдан авсан	Шилжүүлэн авсан	Үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл
Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл	479,330.2	72,887.9	3,487.9	69,400.0	552,218.1
Хуримтлагдсан элэгдэл	154,949.7	44,678.8			199,628.5
Үндсэн хөрөнгийн цэвэр дүн	324,380.5	28,209.1	3,487.9	69,400.0	352,589.6

Биет бус хөрөнгөд 795.0 мянган төгрөгийн анхны өртөгтэй, 545.0 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй программ хангамж, 186940.0 мянган төгрөгийн үнэлгээтэй газар бүртгэлтэй байна.

Үзүүлэлт	Программ хангамж	Хасагдуулаг	Бусад биет бус хөрөнгө	Нийт дүн
Үндсэн хөрөнгийн оны эхний үлдэгдэл	545.0	545.0	186,940.0	186,940.0
Нэмэгдсэн	250.0			250.0
Үлдэгдэл өртөг	795.0	545.0	186,940.0	187,190.0

Оны эхэн дэх 2832.8 мянган төгрөгийн өр төлбөрийн 2694.0 мянган төгрөг нь Тулгат багана ХХК-д бараа үйлчилгээний зардлын өглөг, 138.8 мянган төгрөгийн хувь хүмүүстэй холбоотой тооцоо байсныг барагдуулж, тайлант оны эцэст өр төлбөргүй байна.

Засгийн газрын оруулсан капитал дансны үлдэгдэл оны эхэнд 275955.1 мянган төгрөг байсан ба тайлант онд өөрчлөлт ороогүй байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 186551.8 мянган төгрөгөөр буюу 1.5 дахин өссөн байна.

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл	Өөрчлөлт
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	390,579.7	577,131.5	186,551.8
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	18,878.9	111,784.9	92,906.1
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	364,806.8	431,429.9	66,623.1
Нэмэлт санхүүжилтийн орлого	6,894.0	33,916.7	27,022.7

Өмнөх оны үзүүлэлтээс орлого материаллаг хэмжээгээр нэмэгдсэн шалтгаан нь тайлант онд үнэ төлбөргүй 111784.9 мянган төгрөгийн хөрөнгө хүлээн авсан, түүнчлэн улсын төсвийн санхүүжилт өмнөх оноос 66623.1 мянган төгрөгөөр өссөн, Ковид-19 вирусн нөхцөл байдлаас шалтгаалж нэмэлт санхүүжилтийн дансаар 33916.7 мянган төгрөгийн эх үүсвэр бүрдүүлсэн зэргээс шалтгаалжээ.

Нийт зардал өмнөх оноос 146445.1 мянган төгрөгөөр буюу 1.4 дахин өссөн байна. Өмнөх оны үзүүлэлттэй харьцуулахад материаллаг өөрчлөлтөд цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл 66060.6 мянга, нормативт зардал 44725.4 мянга, үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол 19218.2 мянга, хангамж бараа материалын зардал 13688.3 мянган төгрөгөөр тус тус өссөн нь ихээхэн нөлөө үзүүлсэн байна.

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл	Өөрчлөлт
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	383,609.3	530,054.4	146,445.1

БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	380,475.3	529,614.4	149,139.1
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	254,945.0	310,582.8	55,637.8
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,322.4	44,745.2	10,422.8
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	24,637.8	25,436.8	799.1
Хангамж, бараа материалын зардал	20,106.3	33,794.6	13,688.3
Нормативт зардал	9,639.9	54,365.3	44,725.4
Эд хогшил, урсгал засварын зардал	4,591.0	8,674.1	4,083.1
Томилолт, зочны зардал	4,580.0	5,301.5	721.5
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,192.3	2,035.2	(157.1)
Бараа үйлчилгээний бусад зардал	25,460.6	44,678.8	19,218.2
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,134.0	440.0	(2,694.0)
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	440.0	440.0	-
Төвлөрүүлэх шилжүүлэг	2,694.0	-	(2,694.0)

Дээрх зардлууд өссөн шалтгаан нь Засгийн газрын тогтоол, шийдвэрийн дагуу цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал нэмэгдсэн, мөн Ковид-19 цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан эмийн зардал, хангамж бараа материалын зардал нь өмнөх оны үзүүлэлтээс тус тус өссөн байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүнд нягтлан бодох бүртгэлийн залруулга хийгдээгүй байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 423324.1 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 423324.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 8105.9 мянган төгрөгөөр өсгөж 431429.9 мянган төгрөгөөр баталсан байна.

Тайлант онд батлагдсан төсөв өмнөх оныхоос 66623.1 мянган төгрөгөөр өссөний дийлэнх буюу 89.2 хувь нь цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 59465.6 мянган төгрөгөөр өссөнөөс нөлөөлжээ.

Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 431429.9 мянган төгрөгийн төсөв баталснаас 431429.9 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс санхүүжилт бүрэн авч, төсвийн нийт зардлын гүйцэтгэл 431429.9 мянган төгрөг буюу 100 хувь бүрэн зарцуулагджээ.

Хөтөлбөр	Зориулалт	Арга хэмжээ	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Хэтрэлт, хэмнэлт
71601	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	430,989.9	430,989.9	0.0
71601	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж,	440.0	440.0	0.0

ДҮН

431,429.9

431,429.9

0.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар Ковид-19, тарваган тахал өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвчлөлийг устгахад зориулж орон нутгийн төсвөөс 24117.5 мянга, урьд оны нэмэлт санхүүжилтийн татан төвлөрүүлэлтийн 2694.0 мянга, төсвийн болон аж ахуйн нэгж байгууллагуудад ариутгал халдваргүйжүүлэлт хийсэн үйлчилгээний орлого 7105.2 мянга, нийт 33916.7 мянган төгрөгийн орлогыг хууль, журамд нийцүүлэн бүрдүүлжээ.

Дээрх нэмэлт санхүүжилтийн эх үүсвэрийг холбогдох арга хэмжээнд зориулалтын дагуу нийт 33916.7 мянган төгрөгийн бараа, үйлчилгээний зардалд зарцуулжээ.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 159 мэдээллээс 2 мэдээллийн мэдээлэх хугацаа болоогүй, 3 мэдээллийг хугацаа хоцроож, 154 мэдээллийг хугацаанд нь оруулсан боловч зарим мэдээллийн тоон үзүүлэлт, дүн, тайлбар зэргийг бүрэн илэрхийлээгүй зөрчил байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 2740.8 мянган төгрөгийн авлага барагдуулах, батлагдсан орон тоог баримталж ажиллах, нийгмийн даатгалын шимтгэлийн суутган тооцоололтой холбоотой зөрчлийг давтан гаргахгүй байхад чиглүүлж өгсөн 3 зөвлөмжийг 87.7 хувьтай биелүүлжээ.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хүснэгтээр харуулбал: /мянган.төг

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж-1 /Авлага үүсгэхгүй байх/	1	2740.8	1	1598.5	1	930.6	63.2
Зөвлөмж-2 /Батлагдсан орон тоог баримталж ажиллах/	1		1				100
Зөвлөмж-3 /НДШ-ийн суутан тооцоололтой холбоотой/	1		1				100
Нийт дүн							87.7

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 10385.2 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 2694.0 мянган төгрөгийн 1 алдааг залруулж, 7691.2 мянган төгрөгийн алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

Санхүүгийн үр дүн болон мөнгөн гүйлгээний тайланд санхүүжилт 2694.0 мянган төгрөгөөр илүү бүртгэсэн байсныг залрууллаа.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн акт, албан шаардлага байхгүй болно.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 7691.2 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц чухал асуудал байхгүй болно

4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт: Авлага, өглөгийн дэлгэрэнгүй бүртгэлийг санхүүгийн программд ангилж бүртгээгүй, түүнчлэн мөнгөн гүйлгээний тайланд цалингийн зардлыг 2509.4 мянган төгрөгөөр, санхүүгийн үр дүнгийн тайланд цалингийн зардлыг 1264.1 мянга, НДШ-ийн зардлыг 2987.1 мянган төгрөгөөр тус тус зөрүүтэй бүртгэж тайлагнасан байна.

1.2. Эрсдэл: Санхүүгийн үр дүн болон мөнгөн гүйлгээний тайлан, бүртгэл журнал буруу илэрхийлэгдэх

1.3. Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "Үнэн зөв байх зарчим", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-д "Санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнана" гэсэн заалтуудтай нийцүүлж ажил гүйлгээг үнэн зөв бүртгэж тайлагнах

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

2. Бараа материалын зарцуулалтад хэрэгжүүлэх хяналтын талаар

2.1. Илрүүлэлт: Нягтлан бодогч нь бараа материал, шатахууны зарцуулалтад бүртгэлээрх хяналтыг хэрэгжүүлээгүй, зарим томилолтын тооцоо бодсон үйлдэл тодорхойгүй, түүнчлэн томилолтын хуудсанд ажилласан хугацаа тодорхойгүй байхад томилолт бодож олгосон байна.

2.2. Эрсдэл: Санхүүгийн дотоод хяналт сулрах эрсдэлтэй

2.3. Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "Нягтлан бодогч нь эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалтуудтай нийцүүлж нягтлан бодох бүртгэлийн удирдлага, дотоод хяналтыг хэрэгжүүлж ажиллах.

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 15 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧИЙН ЖАГСААЛТ

Огноо:	Аудитын нэр:	Зоонозын өвчин судлалын төвийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2020			ХОА-2021/5/СТА-ТШЗСН
Шалгагдсан байгууллагын нэр:	Зоонозын өвчин судлалын төв		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Авлага, өглөгийн дэлгэрэнгүй бүртгэлийг санхүүгийн программд ангилж бүртгээгүй, түүнчлэн мөнгөн гүйлгээний тайланд цалингийн зардлыг 2509.4 мянган төгрөгөөр, санхүүгийн үр дүнгийн тайланд цалингийн зардлыг 1264.1 мянга, НДШ-ийн зардлыг 2987.1 мянган төгрөгөөр тус тус зөрүүтэй бүртгэж тайлагнасан байна.	7691.2	Зөвлөмж	Дарга, нягтлан бодогч	Б.Баяржаргал Ш.Хабива
2	Нягтлан бодогч нь бараа материал, шатахууны зарцуулалтад бүртгэлээрх хяналтыг хэрэгжүүлээгүй, зарим томилолтын тооцоо бодсон үйлдэл тодорхойгүй, түүнчлэн томилолтын хуудсанд ажилласан хугацаа тодорхойгүй байхад томилолт бодож олгосон зэрэг алдаа зөрчлүүд байна.	-	Зөвлөмж	Дарга, нягтлан бодогч	Б.Баяржаргал Ш.Хабива
3	Санхүүгийн үр дүн болон мөнгөн гүйлгээний тайланд санхүүжилт 2694.0 мянган төгрөгөөр илүү бүртгэсэн.	2694.0	Залруулсан	Дарга, нягтлан бодогч	Б.Баяржаргал , Ш.Хабива
дүн		10385.2			

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР